157				АЗДҮАХ 3.5.1.3	Арга хэмжээ	Аймгийн төвийн дулааны станцын ажлын цахилгаан хамгамж, дэд станцийн ажлыг	Барилгын ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	50	1,628.0			ХБТХОХ ГХБХБГ	40			
158				АЗДҮАХ 3.5.1.4	Арга хэмжээ	Сайнцагаан сумын 12, 30, 6-р байрнуудын дээвэр, пасадны засварын ажлыг хийх	Засварын ажлын гүйцэтгэлийн дундаж	хувь	2023	7	3		370.5		ХБТХОХ ГХБХБГ				
НИЙТ ДҮН 100 хувь-125, 97.5, 90.7,				88.5, 85.7,	85, 83.3,	70 хувь- 2, 67, 48.2, 28.5, 50, 30хувь-3,	0 хувь-18					51,173.9	12,934.5	12,972.9					

Хэрэгжилт бичих талбар	
Хэрэгжилт	
Сайнцагаан сумын 4, 6-р цэцэрлэгийн авто зогсоолын тохижилтын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 198,306,728 төгрөгийн хөрөнгөөр Сакод Импорт ХХК хийж гүйцэтгэн Барилга байгууламжийг ашиглалтад авах комисст хүлээлгэн өгсөн.	100
Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн барилгын ажлын нийт төсөв 3,346.7 сая төгрөг бөгөөд 2024 онд 1,061.50 сая төгрөг төсөвт суугдан цэцэрлэгийн барилгын ажлын явц 65 хувьтай байна. Барилгын газар шороо, суурь, каркас, гадна дотор ханын өрлөг, гадна цахилгаан холбоо, ариутгал татуургын шугамын ажил хийгдэж зогссон. 2024 онд 1,061.5 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд улсын төсвөөс үлдэгдэл санхүүжилт 2,285.2 сая төгрөг төсөвт суугдсан. 2025 онд барилгын ажил дуусахаар төлөвлөгдсөн байна.	100
2023-2024 оны жилийн эцсийн байдлаар сургуулийн өмнөх боловсролын 22 цэцэрлэгийн эрхлэгч 18, аргазүйч 18, бүлгийн багш 100, туслах багш 55, ажилтан 54 нийт 245 албан хаагч өөрийн аймгийн цэцэрлэгүүд болон Улаанбаатар хотын цэцэрлэг, хөрш зэргэлдээ аймгуудын цэцэрлэгүүдээс туршлага судалснаар гадна талбайн тохижилт, хөгжмийн кабинетын тохижилт, сургалтад апплейкэйшн ашиглах, гадна талбайн тохижилт, хөгжөөн баясах чийрэгжүүлэлт, хэл ярианы сургалт үйл ажиллагааны арга зүй, хөгжмийн сургалт үйл ажиллагааны арга зүй, Монгол ёс заншлыг сургалтын хөтөлбөрт тусган үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, багш ажилчдад цагийн менежмент гэх мэт бусад байгууллагын шинэлэг ажлуудыг өөрийн ажилд тусган ажилласан нь үр дүнтэй ажил болсон байна. 2024 онд Эрдэнэдалай -2, Говийн -Ирээдүй-1, Эрдмийн далай -1, Мандал сургууль-4, Сайнцагааны 4 дүгээр цэцэрлэг-1, Хүмүүнлэг сургууль- 1 нийт 10 багш, удирдах ажилтан Япон, Солонгос улсад туршлага судалж, орон нутгаас 20.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээ.	100
"Чадварлаг багш" хөтөлбөрийн хэрэгжилт, төлөвлөлтийг сургалтын 41 байгууллагаас тоон тайлан авч нэгтгэн дүгнэж, цэцэрлэг, сургуулийн тайлангийн хурлаар хянан хэлэлцэхэд 87.5 хувьтай дүгнэгдэв. Чадварлаг багш хөтөлбөрийн багшийн онолын мэдлэгийг дээшлүүлэх зорилтыг аймгийн Эрдэнэдалай, Гурвансайхан, Сайнцагаан сумын Эрдмийн далай, Цэгц билиг, Мандал сургуулиуд үр дүнтэй хэрэгжүүлснээр элсэлтийн ерөнхий шалгалтын дүн өмнөх оноос 4 хичээлийн гүйцэтгэл 1,36-12.46 оноогоор ахиж, Сайхан-Овоо, Өлзийт, Дэлгэрхангай, Адаацаг, Баянжаргалан, Дэрэн сумд багшийн хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллан багшийн хөгжлийн төв байгуулан, Баянжаргалан, Дэлгэрхангай, Цэгц билиг, ГИЦС багш нарын улсын төрөлжсөн олимпиадад багш суралцагчдыг амжилттай бэлтгэн, багшаа чадваржуулж, 4 багш, 4 суралцагч улсаас эхний байруудад шалгарсан үр дүнг үзүүлээ. Мөн эрдэм шинжилгээний бага хуралд аймгийн сургууль, цэцэрлэгийн илтгэлүүд улсад 3-р байр, тусгай байрт тус тус шалгарсан нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүн гэж үзэж байна. ЕБС-ийн хэмжээнд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэ оны эхний хагас жилд 206 удаагийн сургалт арга хэмжээнд нийт 4240 багш нар хамрагдан 73.2 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс арга хэмжээний тоо 10-аар, гүйцэтгэлийн хувь 2.2 хувиар өссөн дүн мэдээтэй байна. Цэцэрлэг, сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилийн "Багш нарын эрдэм шинжилгээний бага хурал"-д аймгийн сургалтын 41 байгууллагын 95.1 хувь буюу 39 цэцэрлэг, сургууль хамрагдлаа. Эрдэм шинжилгээний бага хуралд энэ онд 221 багш баг болж оролцсон нь өмнөх жилийн оролцогчдоос 117 багшаар ахисан сайн үзүүлэлттэй байгаа нь багш нар багаар судалгааны ажлыг боловсруулах чадвар ахиц гарсан гэж дүгнэж байна	100

Сайнцагаан сумын 960 суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгын ажлыг "Си Эйч Би Жи Констракшн" ХХК гүйцэтгэн байгууламжийг улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авсан байна.	100
Сайнцагаан сумын 640 суудалтай Хүмүүнлэг сургуулийн барилгын ажлыг "Си Эйч Би Жи Констракшн" ХХК гүйцэтгэн байгууламжийг улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авсан байна.	100
Дэлгэрхангай сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг "Ривал констракшн" ХХК 194,664,564 төгрөгөөр гүйцэтгэж Барилга байгууламжийг ашиглалтад авах комисст хүлээлгэн өгсөн.	100
Говь-Угтаал сумын сургуулийн 80 хүүхдийн дотуур байрны гадна, дотор шугам сүлжээний ажил хийгдсэн дотор засал гадна тохижилтын ажил хийгдэж байна. Нийт төсөвт өртөг 2.4 тэрбум төгрөг бөгөөд 2024 онд 1,000.2 сая төгрөг батлагдсан байна. 2024 оны 12-р сард ашиглалтад орно. Барилгын ажлын явц 90 хувьтай байна.	83.3
Тус ажлын тендерийг 3 удаа зарлаж амжилтгүй болсон.	0
"Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл"-ийн 3 дугаар ээлжид 8 сум хамрагдсан. Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрцогт, Дэрэн сумдад сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг "Сайрын харгана" ХХК гүйцэтгэсэн. Говь-Угтаал, Луус, Хулд, Өндөршил сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг "Ашид бюлдинг" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100
Говийн ирээдүй болон Хүмүүнлэг сургуулийн мэдээлэл зүйн SMART кабинет байгуулах ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар Мобинет ХХК 234,415,720 төгрөгөөр гүйцэтгэсэн.	100
МУБИС-ийн харьяа Моноцүкүри төвөөс Эрдмийн далай, Эрдэнэдалай, Адаацаг, Дэлгэрхангай, Хулд, Луус, Говь-Угтаал, Сайхан-Овоо сумдын сургуулиуд нийт 52 сая төгрөгийн өртөг бүхий 26 багц хэрэглэгдэхүүнийг улсын төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалтаар худалдан авч хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Өмнөх онд 5 сургуульд нийлүүлэгдсэн бөгөөд энэ хичээлийн жилд нийт 13 сургуулийн 17 багш хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа нь нийт багшийн 89.5 хувийг эзэлж байна. Боловсролын газрын мэргэжилтэн физикийн багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлэгтэй хамтран физикийн туршилтад хичээл, үзүүлэх сургалтыг 1 удаа, судалгаат хичээлийг дунд, ахлах ангийн хэмжээнд нийт 7 удаа зохион байгуулж ажилласны үр дүнд багш нарын аргагүй ур чадварт ахиц гарч аймгийн тэргүүлэх зэрэгтэй багш нарын ур чадварын уралдаанд 2 багш тэргүүлж, элсэлтийн шалгалтын физикийн судлагдахууны дундаж оноогоор улсад 2 дугаар байр эрэмбэлэгдээд байна. Мөн хөдөөгийн сумын багш нарын мэдлэг, туршилтад хичээл зохион байгуулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Говь-Угтаал, Дэлгэрцогт суманд тэргүүлэх зэрэгтэй багш нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллаж моноцүкири хэрэглэгдэхүүн ашиглан хамтран хичээл бэлтгэн явууллаа.Энэ хичээлийн жилд	100
Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн спорт заалны дээврийн засварын ажилд орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр 249,531,463 төгрөгийн төсөв баталсан. Тус ажлын тендерийг зарлаж 12 сарын 13-ны өдөр нээсэн боловч амжилтгүй болсон.	0
Мандал сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлд ОНТ-өөр 16.5 сая төгрөгийн аяга таваг угаач, ногоо хэрчигч, аяга таваг ариутгагч зэргийг Чиглэл ХХК хүлээлгэн өгсөн.	100

Орон нутагтаа тогтвортой үр бүтээлтэй ажиллаж байгаа багш нарыг багаар нь урамшуулах журам нь 2023 онд зөвхөн элсэлтийн шалгалтад бэлтгэсэн багш нарыг урамшуулж байсан бол 2024 онд журмыг өргөжүүлэн шинэчлэн баталснаар орон нутагт тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж байгаа сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын багш нарын баг, удирдах ажилтанг шалгаруулахаар "Багш нарын баг, удирдах ажилтныг шалгаруулан урамшуулах журам"-ын хэрэгжилтийг зохион байгуулж 181 багш, удирдах ажилтанг шалгаруулан 343.0 сая төгрөгөөр урамшууллаа. Дундговь боловсролын чанар төслийн хүрээнд Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Говийн ирээдүй сургуульд ISO стандарт нэвтрүүлэхээр мөн Цагдаагийн албан хаагчдад анги хэлний мэдлэгийг дээшлүүлэхээр гэрээ байгуулагдан үе шаттай сургалтууд явагдаж нийт 149 албан хаагчид хамрагдаж байна. Багш, удирдах ажилтныг гадаадад оронд 6 албан хаагчийн туршлага судлуулж, Хөдөөгийн багш нарын спортын наадамд оролцогч 50, Хантий аймгийн Чингис хотод зохион байгуулсан Насан туршийн боловсролын төвийн албан хаагчдын сургалтад 13 албан хаагчийг хамруулсан. 6 сургууль цэцэрлэг, номын сангийн тохижилт, тоног төхөөрөмжид 77,38 сая төгрөгийг зарцуулсан. Монгол улсын гавьяат багш Н.Өлзийн нэрэмжит олимпиадыг 481 сурагч, 36 багшийг хамруулан зохион байгуулж, мэдлэг ур чадварыг нэмэгдүүллээ. Номын баяр арга хэмжээний хүрээнд Ухаалаг утаснаас уншлагын цагруу чуулга уулзалтаар 200 сурагч оролцож, сургууль тус бүр номын	100
Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан хөдөөгийн багш нарын 5 төрөлт спортын наадамд 50 багш аймгаа төлөөлөн амжилттай оролцож 3 төрлөөр 4-р байрт, 2 төрлөөр 6-р байрт шалгарсан амжилттай оролцсон байна	100
"Дундговь-Геометр" хөтөлбөрийг Сайнцагаан сумын Цэгцбигийг сургууль санаачлан аймгийн БШУГ, аймгийн ЗДТГ хамтран 2023-2024 оны хичээлийн жилд ердийн сургалттай 18 сургуулийн 9-р ангийн 32 бүлгийн 700 суралцагчийг, гүнзгий сургалттай сургуулийн 8-10-р ангийн 6 бүлгийн 200 орчим суралцагчийг хамруулан ердийн сургалттай 9-р анги, гүнзгий 8-10-р анги нийт 2 төрлөөр олимпиадыг 3 үе шаттай зохион байгуулсан. 8,9,10-р анги, багш гэсэн 4 ангилалаар ердийн, гүнзгий гэсэн 2 төрлөөр ангилал тус бүрд 1-3 байр эзлүүлж нийт 24 анги бүлэг болон бэлтгэсэн багшийг шалгаруулж нийт 5.0 сая төгрөгөөр аймгийн Засаг дарга шагнаж урамшууллаа.	100
2024 онд бага ангийн 4457 суралцагчид хамрагдсан. Мөн 22 цэцэрлэгийн 3128 хүүхдийг хамруулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн "Сүү" хөтөлбөрт 2024 онд жилийн эцсийн байдлаар 208.7 сая төгрөг, 22 цэцэрлэг 35.6 сая төгрөг нийт 244.3 сая төгрөгийг зарцуулаад байна. Тооцоололд тусгагдсан цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд хөтөлбөрт 100 хувь хамрагдаж байна	100
Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу танхимын сургалтыг 357 удаа 28859 иргэнийг хамруулан 5125 ширхэг гарын авлага материалыг тараан зохион байгуулсан байна. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын олон нийтийн цахим мэдээллийн хэрэгслээр 512 удаа мэдээлэл, зөвлөмжийг түгээж хандалтаар 213,809 хүн үзэж мэдээлэл авсан байна. Нийт танхимаар зохион байгуулсан сургалт арга хэмжээний тоо 357, . Мэдээлэл, сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэд давхардсан тоогоор 45783 буюу 90,0 хувьд хүргэсэн байна.	100
Иргэдэд халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор 5125 ширхэг гарын авлага, зөвлөмж, "Давсны хэрэглээг хянах Дэлхийн 7 хоног", харшил өвчнөөс сэргийлэх, Агаарын бохирдол болон амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх, Агаарын бохирдол болон амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх, "Тамхи хүний эрүүл мэндийн үзүүлэх хор хөнөөл" зэрэг 74 сэдвээр 28938 иргэнд гарын авлага, зөвлөмжийг тус тус тараалаа . Нийт 34063 гарын авлага тараалаа.	100
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын үзлэгт 0-5 нас хамрагдвал зохих 6283 хүүхдээс хамрагдсан 4471 буюу (71.2%), 6-17 насны хамрагдвал зохих 10338 хүүхдээс хамрагдсан 8446 буюу (81,7%), 18-аас дээш насны хамрагдвал зохих 30578 иргэнээс хамрагдсан 9400 буюу (30,7%) -ийг тус тус хамруулсан байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг багцын үзлэгт эхний 11 дугаар сарын байдлаар нийт хамрагдвал зохих 47199 иргэнээс хамрагдахаас 22273 хамрагдаж 47,2 хувьтай байна.	100

Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 22395 иргэнээс 16149 буюу 72,1%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 15747 иргэнгээс 13178 буюу 83,7%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2301 иргэн иргэнээс 1770 буюу 76,9%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8044 иргэн хамрагдахаас 6003 буюу 74,6%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитай 63, чихрийн шижинтэй 4 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмчилгээнд хамрууллаа. Үүний үр дүнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 76,8 хувьтай байна.	100
Заавал хийх товлотт дархлаажуулалтад 8751 хүүхэд хамрагдахаас 8322 хамрагдаж хамрагдалт 95,1, томуугийн дархлаажуулалтад 3230 хүн хамруулахаас 3230 хүн хамрагдаж 100 хувьтай байна. Тарилгатай халдварт өвчин бүртгэгдээгүй байна.	100
"Хүний папиллома вирусын эсрэг вакциныг товлотд бэлтгэх үйл ажиллагааны бэлтгэл хангах нь" ДЭМБ, Халдварт өвчин судлалын үндэсний хамтарсан сургалтыг нийт 36, чадавхижуулах сургалтыг танхимаар болон цахимаар 5 удаа буюу 215 эмч, дархлаажуулалт хариуцсан сувилагч мэргэжилтнүүдэд зохион байгууллаа. Нийт сургалтын тоо 6, хамрагдсан мэргэжилтэн 251	100
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд өнгөрсөн оны мөн үед 4,0 промилль байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 11,6-оор буурсан байна.	100
Эхний 11 сарын байдлаар нийт 500 эх төрж, амьд төрөлт 502 бүртгэгдсэн. Нийт төрсөн эхчүүдийн 96,0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтад төрсөн байна. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.	90,7
Эхний 11 сарын байдлаар нийт 490 эх хяналтанд орсноос 474 эх эрт, 16 эх хожуу хяналтад орж жирэмсний эрт үеийн хяналт 96,7 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 5,7 хувиар өссөн.	
Эрдэнэдалай, Гурвансайхан, Хулд, Луус, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдэд ДЭМБ-ын санхүүжилтээр мобайль технологиор хангагдсан. Ингэснээр өссөн дүнгээр 15 сумын эрүүл мэндийн төвийн мобайль технологиор боллоо.	100
Аймгийн нэгдсэн эмнэлгийг мэс заслын стандартад нийцсэн вакуум өрөөтэй болгох зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг Турнинг ХХК 19.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Тендер шалгаруулалтыг 12 сарын 2-ний өдөр хийсэн бөгөөд гүйцэтгэгч компани орж ирсэн байна.	0
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 978,184,000 төгрөгийн үнэ бүхий Автомашинд суурилсан нүүдлийн клиниктэй болсон.	100
Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг барих тендер зарлагдаад шалгаруулах шатандаа явж байна. 2025 оноос баригдаж эхлэх бөгөөд 2024 онд нийт эрүүл мэндийн салбарын барилгыг хойшлуулсан гэсэн мэдээллийг ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга танилцуулсан болно.	0
Өлзийтмандал өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн төмөр, коридорын хэсэг засагдаж 100 хувь дууссан.	100
2024 онд Боржгонмандал өрхийн эрүүл мэндийн төвд 299,0 сая төгрөгийн цэвэр бохирын холболт хийгдсэн. Өргөтгөлийн ажил 2025 онд хийгдэхээр хойшилсон.	0

Адаацаг сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн цэвэр бохир усны засварын ажил бүрэн хийгдлээ. Засвар ажлын гүйцэтгэл 100 хувь	100
"Язгуур өргөө" ХХК төндөрт шалгарч Луус сумын эрүүл мэндийн төвийн туслах барилгын дээврийн засвар, гадна пасад, дотор хойд талын 4 өрөөний хана тааз, бүх цонх гээд бүтэн барилгын засварт, нийт 110,0 сая төгрөгийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн.	100
Орон нутгийн хөгжлийн сангийн 130,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Сумдын Эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж" нийлүүлэх гэрээний дагуу Мехатроник ХХК-тай байгуулсан гэрээгээр Эхо аппарат /зөөврийн/, 12 сувагтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, биохимийн хагас автомат анализатор, гематологийн анализатор аппарат, хяналтын монитор, дефибрилятор зэрэг 15 нэр төрлийн, 24 ширхэг тоног төхөөрөмжийг сумдын эрүүл мэндийн төвүүдэд олголоо. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 92.1 хувьтай байна.	100
Нийт 15 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төв, уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгүүд 2023 онд 100 хувь хог хаягдлын автоклаваар хангагдсан. Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Зоонозын өвчин судлалын төвд НҮБ-ын Хүүхдийн сангийн 396.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар STERIPUS-40 маркийн хог хаягдлын автоклаваар тус тус хангагдлаа. Ингэснээр эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд хог хаягдлыг бүрэн ариутгалд оруулах боломж бүрдсэн	100
Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдсан "Эрүүл- Монгол хүн", "Эрүүл мэндийн цахим гүйлт, "Дасгал Хөдөлгөөн хийцгээе", "Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих" сарын аян, "Энэ жилдээ - Эрүүл жиндээ", "Нэг анги нэг өглөө", "Цаг гаргая", "Илүүдэл жингүй Эртэч монгол", "Бүжгээр эрүүлжье", "Жин хасах 2 сарын аян", "Эрүүл чийрэг Дундговчууд" аян, "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд "Биеийн тамир, спортын бүтээлч сар-2024" арга хэмжээ, "Мандалговь бүх нийтийн кросс", "Нийтийн бүжгээр бүжиглье", " Ахмадын спортын 4 наадам", " Ерөнхий боловсролын сургуулиудын намрын спартакиад", "Спиннинг", "Йог", "Хийн дасгал" зэрэг 18 төрлийн арга хэмжээнд нийт 29100 иргэн тогмол хамрагдсан байна. Нийтийн биеийн тамир, эрүүл идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортын төрлөөр хичээллэгсдийн тоо 2024 онд 35020-д хүрсэн байна.	100
2024 онд аймгийн хэмжээнд 15 сум, 18 заал, 5 клуб, 9 танхим, 43 байгууллага дээр давхардсан тоогоор нийт 29100 иргэн идэвхитэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэж байна. Өглөөний алхалт, зөөлөн гүйлт, дугуй унах, дасгал, бүжиг, явган аялал, спортоор хичээллэх, нийтийг хамарсан спортын арга хэмжээнд нийт 10627 иргэн хамрагдсан. Мөн 11 дүгээр сарыг Соёлын бүтээлч сар болгон зарласантай холбогдуулан Биеийн тамирын бүтээлч сар аяныг зохион байгуулж, Эрүүл Дундговьчууд уриан дор иргэдийг дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломжийг бүрдүүлэн өглөө 07:00-08:00 цагт спорт зааланд Говийн наран бүжгийн клубын багш Б.Наранхүүгийн удирдлага дор дасгал хөдөлгөөн, шугаман бүжгийг иргэдэд заан, хичээллүүлээ.	100
Усан бассейн бүхий спорт цогцолборын ажлыг 2024 онд улсын төсвийн 4.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэлийг "Жи жи ай" ХХКомпани хоёр давхрын карказ, суурийн дүүргэлт зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна. 2024 онд барилгын гүйцэтгэлийн ажил 77 хувьд хүрсэн байна.	100
Луус сумын спорт заалны барилгын төсөв нь 2024 оны улсын төсвөөр батлагдсан бөгөөд зураг төсвөө гаргах бэлтгэл ажлыг хангаад байна. Хагас жилийн байдлаар барилгын ажил эхлээгүй	0
Говь-Угтаал сумын спорт заалны барилгын угсралтын ажлын гүйцэтгэгч "Бум констракшн" ХХК 2024 оны улсын төсөвт 500,0 сая төгрөг батлагдсан. Хагас жилийн байдлаар барилгын ажил эхлээгүй.	0
Говь-Угтаал сумын нийтийн биеийн тамирын талбайн өргөтгөлийн ажлыг "Роуд дэвэлпмент" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 100 хувьтай үргэлжилж байна.	100

Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлын хүрээнд Үндэсний сурын харваа тэмцээнийг 3 удаа, өвлийн харваа тэмцээнийг 1 удаа, үндэсний бөхийн барилдааныг 4 удаа, үндэсний шагайн харваа тэмцээнийг 4 удаа, Хаврын бүсийн морин уралдаан 1 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд тус тэмцээнүүдэд нийт 52 баг оролцон байна. Мөн 2024 оны 08 дугаар сард зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, Үндэсний уламжлалт спорт, тоглоом, наадгайн түүх, онцлог, амжилтууд, үндэсний спортын төрлөөр Дундговь аймгаас төрөн гарсан алдар цуутай хүмүүсийн талаарх мэдээлэл, шагайн наадгай, оньсон тоглоом, үндэсний шагайн харваа, үндэсний сурын харвааны эдлэл, хэрэгслээр гэрээ тохижуулан, гадаад дотоодын 670 гаруй үзэгч, зочид төлөөлөгчдөд тайлбарлан, танилцууллаа. Түүнчлэн Монгол үндэсний сур, шагай, бөхийн секц дугуйланг тогтмол хичээллүүлж, өсвөр үеийн тамирчдыг бэлтгэж байна.	100
Үндэсний сурын харваа, үндэсний бөх, шагайн харваа, ширээний шагай, мөсөн сурын харваа, Мандалын хурд, адучин тэмцээн зэрэг үндэсний спортын 7 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулж, секц дугуйлан хичээллүүлснээр үндэсний спортыг сонирхон хичээллэгчдийн тоо 500 гаруй болж өсөн нэмэгдэж байна.	
Хөтөлбөр арга хэмжээнд нийт 307 иргэнийг хамруулж байнгын ажлын байраар хангаж ажиллалаа. Үүнд: - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Ахмадын санхүүгийн дэмжлэгт 30 иргэнийг хамруулж 240,0 сая - Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 30 иргэнийг хамруулж 300,0 сая - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 14 иргэнийг хамруулж 109,6 сая - Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 1 багийн 2 иргэн хамрагдаж 10 сая төгрөг. - малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 200 иргэнийг хамруулж 1,597.0 сая, - Жижиг зээлд 3 аж ахуй нэгж байгууллага, 5 иргэнийг хамруулж 295,0 сая төгрөг, нийт 2551,6 сая төгрөгийн санхүүжилт олголоо. Мөн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 13 аж ахуй нэгж 1870,0 сая төгрөгийн санхүүжилт авч 23 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна. Үр дүн: Иргэдийг хөтөлбөр арга хэмжээнд хамруулснаар 107 иргэн байнгын ажлын байраар хангагдаж, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн. Малжуулах хөтөлбөрт хамрагдсан 200 өрхийн ажлын байр хадгалагдаж үлдсэн байна.	100
2024 онд 15 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхээс 14 аж ахуй нэгж байгууллагад төлөвлөгөөт, 6 аж ахуй нэгж байгууллагад урьдчилсан хяналт шалгалт, нийт 20 аж ахуй нэгж байгууллагад хийж гүйцэтгэсэн. Дээрх төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгж байгууллагаас 9 буюу 45 хувь нь хөдөлмөрийн харилцааны дотоод хяналт хийж хэвшсэн байна.	100
Хөдөлмөрийн харилцааны чиглэлээрх сургалт мэдээллийг 58 аж ахуй нэгж байгууллагын 571 хүнийг хамруулан 4 удаа зохион байгуулсан. Сургалтын үр дүнд 13 аж ахуй нэгж байгууллага нь 12 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч ажиллуулж, 5 аж ахуй нэгж байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулаагүйн зөрчилд 50.920.000 төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлээд байна. Мөн 25-аас дээш ажилтантай төрийн байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүнээс худалдан авалт хийж хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйлд заасан төлбөрөөс хөнгөлөлт эдлэх боломжийг ашиглаж эхлээд байна.	100

Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд салбарын 18 байгууллагад соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын шавь сургалтыг зохион байгуулах талаар арга зүйн зөвлөгөө өгснөөр дуу, хөгжим, драм, уран зураг, боловсролын хөтөлбөр гэсэн 5 агуулгын хүрээнд 42 төрлийн дугуйланг тогтмол хичээллүүлж, музейн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх болон өвлөн уламжлагчийг нэмэгдүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулж ажиллаа. Жишээлбэл: Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил"-ийн ажлын төлөвлөгөөнд санал тусган оруулснаар Улсын ахлах засуулч, морь цоллооч Т.Цэрэндаваа, Монгол улсын хүндэт засуулч О.Жанчивдорж, уртын дуучин Х.Эрдэнэцэцэг нартай сургагч багшаар ажиллуулах гэрээ байгуулж, мартагдаж буй соёлын биет бус өв болох гийнгоо бөх, морины цол дуудах шавь сургалтыг зохион байгуулж, аймгийн хэмжээнд 65 хүүхэд, соёлын төвд 9 сургагч багшийг бэлтгэлээ. Аймгийн удирдлагын бодлого зохицуулалтаар дэмжигдэн, шаардлагатай 3,5 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлсэн.	100
Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн бүртгэлд Соёлын өвийн үндэсний төвөөс ирсэн чиглэлээр сайжруулан 370 өвлөн уламжлагч бүртгэсэн. 2024 онд 850 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан соёлын өвийг түгээн дэлгэрүүллээ.	
Цагаандэлгэр сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын батлагдсан төсөвт өртөг 2,288.2 сая төгрөг, гүйцэтгэгч компани Хэрмээдэй ххк барилгын ажил эхлээгүй ба ажлын гүйцэтгэл өмнөх оны гүйцэтгэлээр 80 хувьтай, гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын ажлын төндөр зарлагдаж гүйцэтгэгч компаниар Мандал шилтгээн ххк шалгарч гэрээ байгууллаа. Үлдэгдэл санхүүжилт энэ оны батлагдсан төсөв 100.0 сая төгрөг. Тайлант онд барилгын ажил эхлээгүй тул санхүүжилт олгогдоогүй. Дэлгэрцогт сумын 250 суудалтай соёлын төвийн барилгын батлагдсан төсөвт өртөг 1,449.3 сая төгрөг. Гүйцэтгэгч компани Одда тайж ххк. Тайлант хугацаанд гадна засвар, талбайн тохижилтын ажил хийгдсэн. Үлдэгдэл санхүүжилт 125.6 сая төгрөг улсын төсөвт батлагдсан боловч барилгын ажил хийгдэхгүй байна. Санхүүжилт олгогдоогүй.	0
Өндөршил сумын "Соёл урлагийн цогцолбор" -ын барилга батлагдсан төсөв 2,796.8 сая төгрөг. Тайлант оны батлагдсан төсөв 500.0 сая төгрөг, эрх шилжилж аймгийн ХААГ-т гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төндөр зарлагдаад Цагааншовх ХХК шалгарсан. Ажил гүйцэтгэх гэрээг Аймгийн Засаг даргатай байгуулсан. Гэрээний дүн 2,792.6 сая төгрөг барилгын ажил 10 хувьтай. Баянжаргалан сумын соёлын төвийн барилгын батлагдсан төсөв 2,868.9 сая төгрөг, тайлант онд санхүүжих дүн 1,434.5 сая төгрөг. Гэрээний дүн 2,816.8 сая төгрөг. Гүйцэтгэгч компани Ашидбьюлдинг ххк. Гүйцэтгэлээр 934.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Ажлын явц гадна дүүргэлт, цахилгаан, гадна бохир, шугам сүлжээний ажлууд хийгдсэн. Дотор шавардлага, дотор цахилгааны ажил хийгдэж, барилгын ажил 50 хувьтай, Дэлгэрхангай сумын соёлын төвийн барилгын батлагдсан төсөв 2,868.9 сая төгрөг, тайлант онд санхүүжих дүн 1,434.5 сая төгрөг. Гүйцэтгэгч компани Брэндшилдэг ххк. Гүйцэтгэлээр 292.1 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон. Ажлын явц 1 дүгээр давхрын карказын ажил хийгдэж барилга угсралтын явц 30 хувьтай үргэлжилж байна.	85.7
Дэлгэрцогт сумын соёлын төвд Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 50.0 сая төгрөгөөр тайзны хөшиг тоноглолтын хөрөнгө оруулалт хийгдлээ	100
Соёл спорт, аялал жуулчлал залуучуудын яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар соёлын салбарын 19 байгууллагад Дууны тоног төхөөрмж, гэрэлтүүлэгний төсөл арга хэмжээний хүрээнд 375 нэр төрлийн 1,081.7 сая төгрөгийн дуу, гарлийн тоног төхөөрөмж 6 ширхэг лэд дэлгэцний хөрөнгө оруулалт хийгдлээ. Соёлын байгууллагуудын дууны болон гарлийн тоног төхөөрөмжийг шинэчлэснээр үйлчлүүлэгчдэд хүрэх үйлчилгээний чанар сайжирч, байгууллагын өөрийн орлого нэмэгдлээ.Тоног төхөөрөмжийн хангалтын дундаж 60 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
Төв халхын дуулалт жүжгийн театрт Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 112.4 сая төгрөгөөр автобустай боллоо.	100
Төв Халхын дуулалт жүжгийн театрт агааржуулалтын систем суурилуулах ажил 70.6 сая төгрөгөөр хийгдлээ.	100

Эрдэнэдалай сумын соёлын төвд 70.0 сая төгрөгийн 8*4 харьцаатай лед дэлгэц, 29.9 сая төгрөгийн тайз дууны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдлээ.Тоног төхөөрөмжийн хангалт 100 хувийн хэрэгжилттэй.	100
Луус сумын соёлын төвийн барилгын их засварын ажил 616.0 сая төгрөгийн гүйцэтгэлээр их засварын ажил хийгдлээ.	100
"Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 22 арга хэмжээний хүрээнд соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн 2620 арга хэмжээ зохион байгууллаа Онцлог ажлуудаас дурьдвал: Монгол гэр үзэсгэлэн-2024, "Монгол бахархал-Ёс заншил", "Монгол улсын Ардын зураач, Урлагийн гавьяат зүтгэлтэн, шог зураач Ц.Байдын "Өгүүлэмж" зургийн үзэсгэлэн, "Амттай ном" бүтээлчээр ном унших хөтөлбөр, "Чихэртэй ном аян", "Ухаалаг утаснаас уншлагын цаг руу аян", "Олуулаа уншъя - номтой нөхөрлөө" аян, "Ангийн номын санч" хөтөлбөр, "Танд ойрхон номын сан", "Номын өртөөгөөр аялцаа" өртөөчилсөн арга хэмжээ, "Өглөөний уншлага", "Дэлхийн номын өдөр", "Ухаалаг утаснаас уншлагын цагт" хүүхдийн анхдугаар чуулган, "Бяцхан уншигч хүүхдүүдийн уншигч зохиолчийн уулзалт зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.	100
"Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилт 22 арга хэмжээний хүрээнд соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн 2620 арга хэмжээ зохион байгуулж 336590 үйлчлүүлэгчид үйлчилсэн байна.	
Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд Дундговь аймгаас эсгий, модон эдлэл урлалын төрлөөр 8 гар урчууд, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Өндөршил, Өлзийт, Эрдэнэдалай сумдад тус бүр нэг удаа гар урчуудын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, нийт 36 гар урчууд, Говийн өнгө- Говийн залуучууд арга хэмжээний үзэсгэлэнд 12 гар урчууд тус тус оролцож 365 бүтээлийг дэлгэн үзүүлж, худалдан борлуулсан.Үзэсгэлэнд нийт давхардсан тоогоор 56 хүн оролцсон байна.	100
Музейн боловсролын хөтөлбөр болон соёл, урлагийн байгууллагуудын дэргэдэх соёл, урлагийн боловсрол олгох дугуйлангуудад шавь сургалтыг соёл, урлагийн 17 байгууллагад 16 төрлөөр зохион байгуулж ажиллалаа. Тухайлбал: Утас зэрэх, эспий ширмэл, уртын дуу, морин хуур, гийнгоо, бөх, морь цоллох зэрэг сургалт	

Хүүхдийг эодож шийтгэхийг эсрэг дэлхийн өдрийг угтан “Зөв үлгэрлэж, зөв хүмүүжүүлье” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж эцэг, эхчүүдэд болон төрийн байгууллагын албан хаагчдад “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр сургалт ХГБХХГ-ын 9 мэргэжилтэн, “ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖ” арилжааны банзуудтай эрсдэлт хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой асуудлаар арилжааны 3 банкны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан зохион байгуулсан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 02 албан даалгаварын хүрээнд хүүхдийн эрх, хамгааллын сургалтыг 12 эцэг эх, асран хамгаалагч, төрийн албан хаагчдад, Аймгийн “Шатар хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд шатар сонирхогч өсвөр үеийн хүүхдүүдэд зориулан “Хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө” шатрын тэмцээнийг 14 хоног тутам уламжлал болгон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Тус тэмцээнд оролцож буй өсвөр насны хүүхдүүдэд бусдадаа зөв үлгэр дуурайлал үзүүлэх, бусдад өөрийгөө зөв илэрхийлж сурах, бусдыг сонсож, ойлгож хүүхэд хүүхэддээ тусалж дэмждэг байхыг уриалж 36 хүүхэд оролцуулсан, “АХУЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЯН” -ны хүрээнд 50 сурагч, “НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ-2024” эмэгтэйчүүдийн эрх чөлөөний алхалтад аймгийн 6 сургуулийн сурагчдын төлөөлөл, Хүүхэд хамгааллын тухай хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж хэрэгжиж эхлэж байгаатай холбогдуулан иргэд, олон нийттэй уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтад 70 сурагчдыг оролцуулсан, “ЦАХИМААР ХАМГААЛЪЯ” арга хэмжээнд 13 сумын 1489 эцэг, эх, асран хамгаалагч, сурагчдын төлөөллийг оролцуулсан, , Нэгдсэн үндэстний байгууллагын “Хүүхдийн сан”-гаас Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлон, түргэвчилсэн үнэлгээ хийж, үйлчилгээний зураглал гарган, хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийлэл, дарамт мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зарим сумдын хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн “НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН” нарыг чадавхжуулах сургалтад хамруулан, сонгогдсон Адаацаг, Дэрэн, Цагаандэлгэр, Луус, Сайнцагаан сумдын нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан нарт чадавхжуулах сургалт, “ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭСРЭГ ДЭЛХИЙН ӨДӨР”-ийг угтан байгууллагын мэргэжилтэн, албан хаагч нарт мэдлэг олгох чадавхжуулах сургалт зохион байгуулсан.	100
Эрсдэлд нөхцөлд байгаа 260 орчим хүүхдийн 46 хүүхдэд хамгааллын үйлчилгээ, 180 хүүхдэд хөгжлийн үйлчилгээ нийт 226 хүүхэд буюу 86,9 хувьд үйлчилгээ үзүүлсэн байна. Аймгийн хэмжээний эрсдэлд нөхцөлд байгаа 1100 орчим гэр бүлийн гишүүдийн 78 иргэнд хамгааллын үйлчилгээ, 368 гишүүнд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, нийт 446 буюу 33,4 хувьд үйлчилгээ үзүүлсэн байна	
Хүүхдийн эсрэг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа. Үүнд: “Зөв үлгэрлэж, зөв хүмүүжүүлье” /333/Өв соёлоо түгээн дэлгэрүүлцгээе 50Архи үгүй амьдрал-Аз жаргал /20/ Аймгийн “Шатар хөтөлбөр” /200/Ирээдүйн эзэд мэргэжил сонголтын аян /200/“Ахуйн ослоос урьдчилан сэргийлэх аян” - /50/“Нэг тэрбумаараа тэмцье-2024 /150/“ E kids, e Family” цахимаар хамгаалъя /1489/Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг өдөр /50/ Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй /7359/Хамтдаа хөгжлийн хөтөлбөр /140/Зуслангийн хөгжлийн хөтөлбөр /374/Сансрын 7 хоног /1155/Рубик шоо, спорт өрөлт /36/Аутизмыг таниулах Ойлогө хайрлая /12/ Хүүхдийн баяр /1610/Ухаалаг	100
Аймгийн хэмжээний эрсдэлд нөхцөлд байгаа 1100 орчим гэр бүлийн гишүүдийн 78 иргэнд хамгааллын үйлчилгээ, 368 гишүүнд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, нийт 446 буюу 33,4 хувьд үйлчилгээ үзүүлсэн байна	100
Бүрдийн уянга хүүхдийн зусланд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, зөөлөн эдлэл нийлүүлэх	0
Өлзийт сумын хүүхэд залуучуудын автомашингүй, Ногоон орчин жишиг тоглоомын талбай байгуулах тендер шалгаруулах шатанд явж байна.	0
Хүүхдийн хөдөлмөрийг устгах дэлхийн өдрийг тохиолдуулан Дундговь аймгийн Цагдаагийн газартэй уулзалт 6? иргэд Хүүхдийн хөдөлмөрийг устгах нь сэтгэлт сэтгэлт зохино	

байгуулж, "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын дагуу 15 байгууллага, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж хүүхэд ажиллуулж байгаа 3 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. Албан шаардлагын хэрэгжилт 100%-тай байна.	100
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн сурталчлах зорилгоор "Гэр бүлийн үнэт зүйл", "Гэр бүлийн харилцаа", "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх", "Гэр бүлийн эрүүл мэнд" гэсэн сэдвийн хүрээнд 15 сургалт нөлөөллийн ажлыг нийт 6527 албан хаагч, иргэдийг оролцуулан зохион байгуулж, гэр бүлийн боловсрол олгож ажиллалаа. Нийт гэр бүлийн 41%-ийг хамруулсан. Гэр бүлийн үнэ цэнэ, Эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлэх үүрэгт нь хувь нэмэр оруулан ажилласан хэдий ч 2023 онд 8 гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн байсан бол 42 болж 5.2 дахин өссөн байна. Нийт 16,875,000 төгрөг зацуулсан байна Үр дүн: Гэр бүлийн үнэ цэнэ, Эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлага дээшилсэн. Үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлэх үүрэгт нь	100
Аймгийн хэмжээнд энэ оны эхний 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл 42 бүртгэгдсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад 5.2 дахин өссөн, зөрчил 94 бүртгэгдсэнийг урьд оны мөн үетэй харьцуулахад 34 нэгжээр буюу 56.6 хувиар өссөн. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 6 бүртгэгдэж 1 нэгээр буурсан, гэмт хэргийн улмаас 12 хүүхэд хохирсон нь урьд оны мөн үеэс гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо 11 нэгжээр буурсан. Гэмт хэргийн холбогдогч, хохирогч хүүхдүүдэд шаардлагатай зөвлөгөө мэдээллээр үйлчилж, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллаж байна	0
Газрын дэргэдэх "Түр хамгаалах байр"-ыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр /250 сая/ шинээр байгуулан, 2024 оны 03 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Түр хамгаалах байраар нийт 21 хүн үйлчлүүлсэн. Үүнээс 15 хүүхэд, 6 насанд хүрэгч байна. Үүнд бэлгийн хүчирхийллийн хохирогч 1, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 20 байна. Хүүхэд: Хүйс эрэгтэй-5, эмэгтэй-10. Насны ангилалаар /0-5/-6, /6-10/-4, /11-15/-5. 30 ба түүнээс дээш хоносон 2 хүүхэд байна. Бие мах бодийн хүчирхийлэлд өртсөн-8, Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн-5, Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн-1, Бэлгийн хүчирхийлэлд өртсөн-1 хохирогч байна. Насанд хүрэгч: Эмэгтэй-6. Насны ангилалаар 25-34. Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн-6 байна. Хүчирхийллийн хохирогч нарт Эрүүл мэндийн үзлэг 17, сэтгэлзүйн зөвлөгөө-15, зөвлөгөө ярилцлага 14 удаа хийж, өдөр бүр шинэ хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, кейс файлыг хааж ажилласан. Мөн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтыг тухай бүр хийсэн. Нийт 7,932,549 төгрөгийг зарцуулсан байна. Үйлчилгээ авсан 15 хүнээс сэтгэл ханамжийн судалгаа авахад сэтгэл ханамж-100%-тай.	100
2024 оны аймгийн хэмжээнд 5942 ахмадаас НЭ-н ахмад-ын кабинетаар 1993 ахмад, сумдын ЭМТ-өөр 2590 ахмад нийт 4583 ахмад ахмадуудын 77.13 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдлаа. Эрүүл мэндийн газар, аймгийн Ахмадын хороотой хамтран урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамруулах үе шаттай арга хэмжээг 2 удаа зохион явуулж, 1304 ахмадад эрүүл мэндийн сургалт зохион байгууллаа.	100
Ахмад настны эрүүл насжилтыг дэмжих зорилгоор ахмадын дасгал хөдөлгөөнийг дэмжих зориулалтын талбайг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 104.9 сая төгрөгийн хөрөнгөөр "Баганадант" ХХК хийж гүйцэтгэсэн. Тус ажил хийгдсэнээр ахмадууд болон хүүхэд залуучуудын амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх тав тухтай орчин нөхцөл бүрдэж байна.	100
Айраг багийн ахмадын төвийн байрыг Дундговь ХХК нь 97.7 сая төгрөг, Аривжих багийн ахмадын төвийн байрыг Нүнжиг ХХК 94.7 сая төгрөгийн өртөгтэйгээр хийж гүйцэтгээд байна. Айраг багийн ахмадын төвийн барилга 100 хувь гүйцэтгэн хүлээн авсан. Аривжих багийн ахмадын төвийн барилга 95 хувийн гүйцэтгэлтэй байна.	97.5
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 32 ахмад хамрагдаж 34.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хөтөлбөрийн хүрээнд 32 түр ажлын байр бий болгож ажиллалаа.	100

Улсын төсвийн 168,185,833 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх аймгийн Ахмадын ордны тавилга, тоног төхөөрөмжийн тендэрт шалгарсан Мээжийн хишиг ХХК 100 хувь тоног төхөөрөмжөө нийлүүлсэн байна. Тоног төхөөрөмжийн хангалтын хувь 100 хувь болсон.	100
Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажил 2020 оноос эхлэн үе шаттайгаар хийгдсээр 2024 оны байдлаар нийт 64 төрлийн үйлчилгээг 90 хувь цахимжуулж ehalmj.mn системд шилжүүлснээр 34573 иргэн цахимаар үйлчилгээ авсан байна.	100
2024 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 17 иргэнийг ажлын байранд зуучилж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санхүүгийн дэмжлэгт 14 иргэнийг хамруулан байнгын ажлын байраар хангаж 109.6 сая төгрөгийн санхүүжилт олгон, нийт 31 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, үүнээс 25-аас дээш ажилтантай 9 байгууллагад 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэн зуучлагдсан байна.	88.5
Байнгын асаргаанд байдаг иргэнээ асарч байгаа 1010 иргэн байгаагаас байнгын ажлын байранд 167, түр ажлын байранд 11, нийт 178 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилж 16.5 хувийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангалаа.	100
Аж ахуй эрхлэлтийн сургалтад хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдээс 4, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг 12, нийт 16 иргэнийг хамруулж, төсөл бичих ур чадвар болон санхүүгийн ур чадвартай болголоо.	100
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан 90 иргэнд нөхцөл байдлын үнэлгээ хийж 34 иргэнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд хамруулж, 33.0 сая төгрөгийн буцалтгүй санхүүжилтийг олгосон байна.	
Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох 8 удаагийн сургалтад хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүдээс 45, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг 66, нийт 111 иргэнийг хамруулаад байна.	100
Сургалтад хамрагдсан нийт 111 иргэнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 5 , ахмадын санхүүгийн дэмжлэгт 9, иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2, нийт 16 иргэнийг санхүүгийн дэмжлэгт хамруулж, байнгын ажлын байраар хангасан байна	
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн 38, байнгын асаргаанд байгаа иргэнийг асарч байгаа 37, нийгмийн халамжийн бусад үйлчилгээнд хамрагдаж буй 118, нийт 193 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, ажлын байраар хангаж ажилласан.	100
Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн-216.3тонныг үйлдвэрлэж–9хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн–2мян.л-ийг үйлдвэрлэж -0.09 хувийг, өндөг-77тонныг үйлдвэрлэж 28 хувийг, мал төхөөрөх цэгт 237.5 тн мах бэлтгэж 14.1 хувийг тус тус хангаж, нийт 51.19 хувийг хангасан байна.	100
Аймгийн хэмжээнд энэ онд өвөл, зуны 154 ш хүлэмжинд буюу 19046 м2 талбайд тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 7 ш буюу 3046 м2 талбайгаар шинээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	...

Энэ онд хүлэмжээс 126,2 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 25,4 тн –оор нэмэгдсэн байна.	100
Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага аж ахуйн нэгжийн нийт 1608 камер ажиллаж байгаагаас 545 хяналтын камерыг нийтийн эзэмшлийн зам талбайг 50 метр хүртэл хянах боломжтой болгож, чиглэлийг тухайн байгууллагатай зөвшилцөн өөрчилсөн. "Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт"-ыг орон нутгийн хөгжлийн сангийн 1,8 тэрбум төгрөгөөр баталж нийт 3 удаа нээлттэй зарлагдсан боловч оролцогчдоос эрх бүхий байгууллагад гомдол гарган цуцлагдсаны улмаас 4 дэх удаа шалгаруулалтыг зарлан "Бодь-Электроникс" ХХК-ний төндэрийг хамгийн сайн үнэлэгдсэн төндэрээр шалгаруулж гэрээг баталгаажуулж байна. Камержуулалт хийгдсэнээр нийтийн эзэмшлийн зам талбайн 90 хувь нь бүрэн камержсан байна. "Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засвар" төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн 824,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр санхүүжүүлэхээр баталж "Сүлд оюу хайрхан" ХХК-ний ирүүлсэн төндэрийг хамгийн сайн үнэлэгдсэн төндэрээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгохоор албан бичиг хүргүүлсэн боловч төндэрт оролцогчоос Сангийн яаманд гомдол гарган цуцлагдаж дахин зарлаад байна.	0
Цагдаагийн газрын парк шинэчлэлт, туулах чадвартай автомашин худалдан авахад шаардлагатай 130,000,000 төгрөгийг шийдвэрлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулан "Ланд-200" маркын автомашиныг хүлээлгэн өгсөн.	100
Төрийн үйлчилгээг ард иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, тэгш, хүртээмжтэй хүргэх, эрүү, иргэн, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг цаг алдалгүй явуулах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тус газрын албан хэрэгцээнд зориулан 25,0 сая төгрөгийн өртөг бүхий төндөрт шалгарсан "Мандал хаалга" ХХКомпани Prius-30 маркийн тээврийн хэрэгслийг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн.	100
Сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг камержуулахаар аймгийн ОНХС-ийн 70 сая төгрөгийн хөрөнгө санхүүг шийдвэрлэн төндөрт шалгаруулалтыг зарласан боловч оролцох аж ахуй нэгж одоогоор санал ирүүлээгүй болно.	0
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 25.0 сая төгрөгийн үнэ бүхий 37 нэр төрлийн химийн лабораторын техник, тоног төхөөрөмжийг "Грийн химистри" ХХК нийлүүлэн 2024.04.19-ны өдөр хүлээн авсан ба тоног төхөөрөмжийн хангалт 100 хувьтай байна.	100
Удирдах бүрэлдэхүүний сургалтыг 9 удаа зохион байгуулж 957 удирдах албан тушаалтныг хамруулан болзошгүй аюулт үзэгдэл, ослын үед ажиллах мэдлэг чадварыг дээшлүүлэн ажилласан. Төрийн болон нутгийн захиргаа, хуулийн этгээдийн сургалтыг 91 удаа зохион байгуулж, 1558 ажилтныг хамруулсан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сургалтыг 87 удаа зохион байгуулж 3148 хүүхдэд, цэцэрлэгийн хүүхдийн сургалтыг 11 удаа 786 хүүхдийг хамруулан зохион байгуулж, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул эрсдэлийн үед өөрийгөө хамгаалах талаар мэдлэг олгож ажилласан. Аймгийн Залуучуудын холбоотой хамтран иргэдийн сургалтыг 6 удаа зохион байгуулж нийт 720 иргэнд өрхийн аюулгүй байдлыг хангуулах талаар мэдлэг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу хөгжлийн танхимын сургалтад 74 хүүхдийг хамруулан аюулгүй амьдрах мэдлэг олгосон. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу орон нутгийн хүн амд гамшгаас хамгаалах тухай мэдлэг олгох, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, 208 удаагийн сургалтад нийт хүн амын 25.7 хувийг хамруулсан.	100

Улсын төсөөс гамшгаас хамгаалах тоног төхөөрөмжийг хагас жилийн хугацаанд шийдвэрлээгүй, гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн сангаас бага орбитод байгаа маш олон хиймэл дагуулуудтай холбогддог өндөр хурдны интернэтийн хөдөлгөөнт "СТАРЛИНК" төхөөрөмжийг 10 сая төгрөгөөр худалдан авч хөдөлгөөнт удирдлагын байранд тоноглож, тохиргоог хийж байрлуулсан. Гамшгийн үеийн холбоог тасралтгүй зохион байгуулах сансрын холбооны өндөр хурдны интернэтийг ашиглах компьютер, хурлын төхөөрөмж дэлгэц, веб камер болон богино долгион, хэт богино долгионы радио станцуудын байнгын бэлэн байдлыг хангаж нөөц үүсгүүр, батарейн цэнэгийг дүүргэж 1 удаагийн үзлэг шалгалтыг зохион байгуулж ажилласан. Алба хаагчдад амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үеийн хээрийн дадлага сургуультай хамтран гамшгийн үеийн холбоог тасралтгүй зохион байгуулах 1 удаагийн дадлага сургалтыг зохион байгуулсан. Гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмж 71 хувьтай хангагдсан.	100
Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд аймгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Дундговь аймгийн хэмжээнд гамшгийн 8 төрлөөр гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын даалгаврыг гарган хүргүүлсэн. Одоогийн байдлаар Тендер зарлагдаж гэрээ байгуулсан.	30
Аймгийн төвд шинээр баригдаж байгаа дулааны станц төслийн гадна цахилгаан хангамж 35/10 кВ-ын 2*2000кВа дэд станцын өргөтгөлийн ажлын 2 дугаар хэлхээний холболтод ЭХЯаманд тендер зарлагдаж гүйцэтгэгчээр Инфраструктур сүлжээ ХХК нь шалгарч угсралтын ажил 50%-тай хийгдаж байна. Угсралтын ажил 2025 оны 12 сарын 30-нд дуусна.	100
"Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл" тус аймгийн Луус суманд хэрэгжиж байгаа бөгөөд гүйцэтгэгч "Бурхан хясаат" ХХК 3,995.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, 50м3 цэвэрлэх байгууламжийн бетон цутгалтын ажил, био цөөрөм, гүний худаг, усан сангийн байгууламж, ус түгээх байрны ажлууд, гадна цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлууд хийгдсэн. Ажлын явц 65 хувьтай.	48.2
Техникийн нөхцөл гаргуулан, тендер зарлуулахаар ажиллаж байна.	0
Тухайн ажлын 1.2 тэрбум төгрөгөөр Барилга хөгжлийн төвд хянагдаж тендер шалгаруулах шатандаа явж байна.	30/0
Мандалговь цэцэрлэгт хүрээлэнгийн амралт зугаалгын бүсийн тохижилтын ажлын тендер зардлагдаж "Мээжийн хишиг" ХХК гэрээ байгуулж ажлын явц 50 Гүйцэтгэлтэй байна.	100
"Гэр төсөл"-ийн тендерт шалгарсан Дөрвөлжийн бэл ХХК гэрээний дагуу 17 иж бүрэн 5-н ханатай гэр нийлүүлж ргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу 17 өрхөд гэрийг гардуулан өгсөн.	
	85
Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн Сан болон Монгол Улсын Засгийн Газрын хамтран хэрэгжүүлж буй "Эх хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах хөтөлбөр"-ийн хүрээнд монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн ЧИП багц хэрэглэх сонирхолтой айл өрхүүдийн судалгаагаар 378 өрх хүсэлт ирүүлснээс орон нутгийн төсөв болон МАК ХХК-ын санхүүжилтээр 1 багцын үнийг 66 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр Сайнцагаан суманд 88, Баянжаргалан суманд 30, Дэлгэрхангай суманд 30, Дэлгэрцогт суманд 2, нийт 150 өрхөд уг багцыг олгосноор нийт 214 өрхийн хэрэглээнд нэвтрүүлээд байна.	100

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Монголын жорлонгийн ууган холбоо ГҮТББ-тай хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Эко жорлон" арга хэмжээ зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 15 сумын удирдлагууд, төрийн албан хаагч, иргэд 120 хүнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүдийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн "Эко жорлон" үзэсгэлэнгээр хуурай технологийн 8 төрөл, электрон ухаалаг нэг, ус хэмнэлтийн хуйлруулагч хошуу бүхий 2 төрөл, соруулдаг нүхэн жорлонгийн 1 төрөл нийт 13 төрлийн жорлонгийн танилцуулга, үзэсгэлэнг 200 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 2024 онд 6 суманд шинээр 27 эко жорлон нэмэгдэж 3 суманд 10 өрх бохирын шугамд холбогдсоноор аймгийн хэмжээний байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийн тоо 203 болж нэмэгдсэн.	100
Сайнцагаан, Адаацаг, Говь-утгаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайхан-овоо, Эрдэнэдалай сумдад дахивар авах цэг ажиллаж байгаа бөгөөд 2024 онд 107.3 тонн дахивар нөөц цуглуулан дахин боловсруулах үйлдвэр болон үйлдвэрлэгч ААН-д тушаасан. Эрдэнэс алт ресурс ХХК нь мөн 40.9 тн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад тушаасан. Нийт ангилсан хог хаягдлын хэмжээ 148.2 тн.	100
Говь-утгаал суманд 9, Өлзийт суманд 7, Хулд суманд 4, Гурвансайхан суманд 15, Дэлгэрцогт суманд 110, Дэлгэрхангай суманд 22, Сайнцагаан суманд 9, аймгийн хэмжээнд нийт 172 ширхэг ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав шинээр бий болж 311 байсан нь 483 болж нэмэгдэв.	100
Дэлгэрхангай сум ОНТ-ийн 90 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Юнивэрсаль трактортой болж 2024 оны 05 сард хүлээж авч ашиглаж байна.	100
Дэлгэрцогт суманд хог зөөврийн машинтай болж 2024 оны 06 сард хүлээн авсан.	100
Эрдэнэс алт ресурс ХХК-ны хөрөнгө оруулалтаар Биологийн нөөцийг хамгаалах төв ТББ-тай хамтран тус аймгийн "Загийн ус", "Дэлгэрхангай уул", "Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газруудад менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлж, улсын тусгай хамгаалалттай газрууд 100% менежментийн төлөвлөгөөтэй болов. "Их газрын чулуу" байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран орчны бусад амьдарч буй иргэдэд хууль бус ан, улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, мод тарих, чиглэлээр 7 удаа сургалт, мэдээ мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулсан. Тус мэдээллийн хүрээнд 2 мэдээллийг боловсруулан, 100 хүнээс байгууллагын санал асуулга бөглүүлэн ажиллав.	100
Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас уулын туруутан амьтадын амьдрах орчныг сайжруулах зорилгоор аргаль, янгирын гол байршил Их газрын чулууны Ихрийн хад, Ервонгийн ам, Ерлөг уул, Баян уулын амуудад нийт 4 бага хэмжээтэй хөв цөөрмийг байгуулсан. Тус хөв цөөрмийг байгуулснаар шөнийн амьдралтай хадны суусар амьтныг Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт байдгийг нотолж, уулын туруутан болон жигүүртэн, махчин амьтдын амьдрах орчин сайжирсан.	100
"Дундговь" ХХК-тай гэрээ байгуулж Өлзийт сумын "Сүүжийн булаг", "Баруун билүүний булаг", Сайхан-Овоо сумын "Өвөр булаг" нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт хашсан булгийн тоо 65 болж нэмэгдсэн.	100

Олгойн говийн ус цэвэршүүлэх байгууламжийн барилгын угсралтын ажлыг "Турнинг" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 100 хувьтай хүлээн авсан.	100
Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Эрдэнэс алт ресурс" ХХК, "Болор жонш" ХХК-ууд баяжуулах үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашигласан усаа 85 хувьтай цэвэршүүлэн, цэвэрлэсэн усныхаа 70% -ийг дахин ашиглаж байна. Мөн Онгийн нууц жуулчны бааз бохир ус цэвэршүүлж, мод, ногоон байгууламжаа усалдаг. "Дундговь-Ус" ОНӨҮГ-азрын 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 400м3/хоног бохир усыг 90%-тай цэвэршүүлж байна. Цэвэршүүлсэн усыг ногоон байгууламж, тэжээлийн ургамлын усалгаанд ашиглаж байна. Нийт хэдэн 3 ААН усыг дахин ашиглаж байна.	70
. Хөтөлбөрийн хүрээнд "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", бүх нийтээр мод тарих өдрийг угтан "Дундговь ногоорууль" үзэсгэлэн худалдаа, "Газар тариалан, хүлэмж, хөдөө аж ахуй, жимсний мод тарьж ургуулах, өвөлжүүлэх агротехнологийн сургалт"-уудыг зохион байгуулсан. Мөн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговь ногоорууль" хөтөлбөр, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 164 аж ахуйн нэгж, байгууллагын 2481 иргэн 181166 мод, сөөгийг тарьж 83 хувьтай ургуулж, нийт модны тоо 466664-д хүрч өмнөх оноос 81,2 хувиар өссөн байна. Улс, орон нутгийн хөрөнгөөр "Агро ойн аж ахуй байгуулах ажил" ойн зурвасыг 78,1 га-д хийж нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 510,5 га-д хүрэв. "Дундговь ногоорууль" дэд хөтөлбөрийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ батлуулан хэрэгжүүлж, 95%-тай байна.	100
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрхангай сумдад нийт 52 га-д мод үржүүлгийн газар байгуулахаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан. Баянжаргалан суманд 2 га-д мод үржүүлгийн газар байгуулахаар хашаа, хамгаалалтын зурвас байгуулах тендер зарлаад байна. Эрдэнэдалай суманд 5 га талбайд мод үржүүлгийн газар байгуулагдсанаар аймгийн хэмжээний мод үржүүлгийн газрын тоо 4, иргэн 4 нэмэгдэж, мод үржүүлгийн чиглэлээр нийт 8 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.	100
"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговь ногоорууль" хөтөлбөр, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд 164 аж ахуйн нэгж, байгууллагын 2481 иргэн 181166 мод, сөөгийг тарьж 83 хувьтай ургуулж, нийт модны тоо 466664-д хүрч өмнөх оноос 81,2 хувиар өссөн байна. Улс, орон нутгийн хөрөнгөөр "Агро ойн аж ахуй байгуулах ажил" ойн зурвасыг 78,1 га-д хийж нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 510,5 га-д хүрэв	100
Тарьсан модны ургалт 83 хувьтай байна.	
Аймгийн Засаг даргын 2024 оны А/330 дугаар захирамжийн дагуу малчдыг тэжээлийн ургамал тариалуулахаар 15 суманд 50,5 тн овъёос, 17,5 тн улаан буудайн үрийг хуваарилан олгосны дагуу Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 75 малчин өрх 49,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалсан. 13 сумын 75 малчин өрх 49,7 га талбайд тэжээлийн ургамал тариалж 57,2 тн ургац хураан авч өмнөх оноос 42 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100

Таваарын буюу хэрэгцээний нийт 1029908 малаас 813734 буюу малын 79,1 хувийг эдийн засгийн эргэлтэд, 216122 мал буюу 20,9 хувийг хүнсэнд хэрэгцээлсэн. Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй Хоршоологчдоос-Хотынхондоо ӨВЛИЙН ИДЭШ өргөтгөсөн худалдаа арга хэмжээнд Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Баянжаргалан сумын 15 малчид оролцож, өнөөдөр буюу 2024.12.17-ны өдрийн байдлаар 70,5 тн мах, цагаан идээ 2.5 тн борлуулж 705.0 сая төгрөгийн борлуулалт хийгээд байна. Бэлчээрийн даацыг аймгийн нийт багийн нутгаар тооцоолж гаргасан дүнгээс үзвэл: 38 % бэлчээрийн нөөцтэй, 38 % бэлчээр хүрэлцээтэй, 22 % даац 1-3 дахин хэтэрсэн, 2 % нь даац 3-5 дахин хэтэрсэн байдалтай гарсан. Өөрөөр хэлбэл аймгийн дүнгээр нутгийн 76 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой байна гэсэн дүгнэлт гаргасан. Харин нутгийн 22 хувьд нь 1-3 дахин хэтэрсэн, 2 хувьд нь 3-5 дахин хэтэрсэн. Дундговь аймгийн хэмжээнд 100 га бэлчээрт хонин толгойд шилжүүлснээр 50 мал байхаас 90 мал ногдож байгаа нь 40 мал илүү байна. Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг зах зээлд борлуулснаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх нэг арга хэмжээ юм.	100
Улсын болон орон нутгийн хөгжлийн сангийн 253,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэрэн нийт 8 сумын 60,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн болон энгийн механик аргаар үлийн цагаан оготготэй тэмцэж, нөхөн сэргээх ажлыг хийсэн. Мөн дээрх сумдад шувууны үүр 100 ширхэг, утагч багаж 8 ширхэг, үлий цөмлөгч 8 ширхгийг хуваарилан олгосон. Тэмцсэн хээрийн техникийн үр дүн 82.7 хувьтай. Өмнөх оноос 20,0 мян.га талбайгаар нэмэгдүүлэн тэмцсэн.	100
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өлзийт, Сайнцагаан, Сайхан-Овоо сумдад инженерийн хийцтэй 3 худаг гаргахаар "Эрхэст-Ундарга" ХХК тендэрт шалгаран гэрээний дагуу 07 дугаар сарын 10-наас Орон нутгийн хөгжлийн санхүүжилтээр гаргах инженерийн хийцтэй 5 гүн өрмийн худаг гаргасан байна.	100
Аймгийн 3 сумын нутаг дэвсгэрийн 5 байршилд уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгж ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4.87 га, хайгуулын үйл ажиллагаанаас эвдэрсэн 0.09 га, эзэнгүй эвдэрч орхигдсон 4.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 157.34 га-д буюу 25.6 хувьд хүрсэн.	100
Баянжаргалан, Дэлгэрцогт, Өлзийт, Дэлгэрхангай, Гурвансайхан сумдад нийт 14 ХХК 19.5 га газарт хувийн хэвшлийн хөрөнгөөр, Дэлгэрцогт, Өлзийт сумдад 11 га газрыг орон нутгийн төсвөөр нөхөн сэргээсэн. Техникийн нөхөн сэргээлт 30.5, биологийн нөхөн сэргээлт 1 га-г хийж нийт нөхөн сэргээсэн талбайн хэмжээ 202.7-д хүрэв.	100
Цөлжилтөнд өртсөн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын судалгааг хийх Говь-Угтаал суманд судалгаа хийлгэхээр байсан боловч төсөв хөрөнгийн асуудлаас болж хийгдээгүй байна.	0
"Монгол тарвага"-ыг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор "Их газрын чулуу" БЦГазарт 50 тоо толгой тарвагыг нутагшуулах ажлыг "Эрдэнэ алт" ХХК холбогдох мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж хамтран хэрэгжүүлсэн.Дэрэн сумын Цагаан толгойд 30, нийт 80 тоо толгойг нутагшуулсан.	100
Ургамлын төрөлжсөн жишиг плантаци байгуулах зорилгоор Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрыг талбайд ашигт ургамлын жагсаалтад орсон Цулбуурт цахилдаг, Чихэр өвс зэрэг ургамлыг 0.5 га-д тарималжуулж, өсөлтийн өндөр 1,8-5,6 см ургуулсан. Цаашид төрөлжсөн ховор, ашигт ургамлыг өргөжүүлэн тарималжуулсан.	100

Аймгийн ЗДТГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 19 арга хэмжээтэй төлөвлөн боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, 4 удаагийн сургалтыг зохион байгуулан ажилласан.Төлөвлөгөөний хэрэгжилт 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлига, хүнд сурталгүй "Дундговь авлигагүй хөгжине" уриалгыг санаачлан хэрэгжүүлсний үр дүнд Авлигатай тэмцэх газраас 2 жил тутамд хийгддэг төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ 75.8 хувьтай дүгнэгдсэн нь өмнөх үеэс 2.9 функтээр нэмэгдсэн. Нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан дүгнэлт/албан бичиг/-ийг аймгийн www.dundgovi.gov.mn сайтын Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт ХАСУМ хянуулсан 5 дүгнэлтийг байршуулан ил тод нээлттэй сурталчилж шударга байдлыг бүрэн хангаж ажилласан.	100
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-ний дагуу жил бүр аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. 2024 онд төлөвлөгөөг 5 зорилго 30 арга хэмжээ бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлээ. Төлөвлөгөөний явцын хэрэгжилт 12 дугаар сарын 01-ны байдлаар 91.2 хувьтай байна. Тус төлөвлөгөөнд орон нутгийн төсвөөс 2.0 сая, төсөл хөтөлбөрөөс 6.0 сая, улсын төсвөөс 80.04 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Жендэрийн 2024 оны статистик үзүүлэлт гарах хугацаа болоогүй байна.	100
Япон Улсын Эхиме мужийн Сейёо хотод хамтын ажиллагааг өргөжүүлэх албан айлчлал хийв. Уулзалтын үр дүнд соёлын салбарын хамтын ажиллагааг эхлүүлэн Дундговь аймгийн уран бүтээлчдийн тоглолтыг Сейёо хотод зохион байгуулах, сурагч хүүхдүүдийн солилцооны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх хэлэлцээрт хүрэв. Гуяан хоттой байгуулсан санамж бичигт тусгагдсан боловсролын салбарын хамтын ажиллагааны хүрээнд солонгос хэлний танхим байгуулан Гуяан хотын Дахам төрийн бус байгууллагаас солонгос багш Дундговь аймагт ирж Политехникийн оюутнууд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад солонгос хэл зааж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хот, Саньяа болон Гуанжоу хотод нийт 65 , Япон Улсад 8, Бүгд Найрамдах Солонгос Улсад 2, нийт 75 төрийн албан хаагчийг гадаадад туршлага судлах хөтөлбөрт хамруулав. Замын-Үүдийн дэд Ерөнхий консултай уулзалт зохион байгуулж цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлов. Зүүн хойд азийн Нутгийн захиргаадн холбоо/NEAR/-ны төрийн албан хаагчдын олон улсын сургалтын хөтөлбөрт орон нутгийн нэг төрийн албан хаагчийг хамруулав. Мөн тус байгууллагаас зохион байгуулж буй олон улсын гар зургийн үзэсгэлэнд сурагчдын бүтээлийг илгээв. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага(ЖАЙКА)-тай хамтран “Үдийн хоолны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” төсөл, Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Пархийн зөв Монгол орон улсын	100
Удирдлагын академийн Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 10, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх давтан сургалтад 6, төрийн албаны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч тус тус улсын төсвийн санхүүжилтээр хамруулаад байна. Мөн Төрийн албаны сургууль Удирдлагын академтай хамтран сумдын багийн Засаг дарга нарыг чадваржуулах сургалтыг 2024.03.22,23-ны өдрүүдэд зохион байгуулж 68 багийн Засаг даргыг хамрууллаа.Мөн Төрийн албаны сургууль Удирдлагын академтай хамтран сумдын багийн Засаг дарга нарыг чадваржуулах сургалтыг зохион байгуулж 68 багийн Засаг даргыг хамруулсан. нийт тоогоо гаргаарай	100

2024 онд "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-аас 450,0 сая төгрөгийг батлуулан төрийн албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, адаад туршлага судлах, орон нутагт дутагдалтай боловсон хүчин бэлтгэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны хагас жилийн байдлаар хөтөлбөрийн хүрээнд Гадаадын 5 улс оронд 23 төрийн албан хаагчийг туршлага судлах үйл ажиллагааны онгоцны зардал, томилолтын зардалд 89.5 сая төгрөг, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа 5 оюутанд 8.1 сая төгрөг, Засаглалын менежмент-Нутгийн хөгжил зөвлөгөөн, Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалт, Залуучуудын хөгжлийн зөвлөлийг гишүүдийг чадваржуулах зэрэг төрийн албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх сургалт зөвлөгөөнд 39.3 нийт 149.4 сая төгрөгийг зарцуулаад байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100
Луус сумын төрийн албан хаагчдын байрны засварын ажлыг "Ривал констракшн" ХХК гүйцэтгэж, 2024 оны 1-р сарын 23-ны өдөр ашиглалтад бүрэн оруулсан.	100
Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засварын ажил хийгдээгүй	0
2024 онд улсын болон болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт 43,8 тэрбум төгрөгийн 91 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн байна. 2024 оны сүүлийн хагас жилийн байдлаар 61 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлан, зохион байгуулаад байна. Төлөвлөгөөний гүйцэтгэл 67 хувьтай байна.	67
Аймгийн ЗДТГ-ын дээврийн засварын ажлыг бүрэн хийсэн	100
Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилгын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. 2025 оны 1 дүгээр улиралд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	100
Сайнцагаан сумын төрийн нэг цэгийн үйлчилгээний барилгын гүйцэтгэгч "Жи Жи Ай" ХХК 3,722.8 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 70 хувьтай үргэлжилж байна.	100
Дэлгэрхангай сумын 4-р багийн төвийн барилга шинээр барих төндөрийн өөрчлөлтийн хүсэлт гарсан.	0
Тус хэлтсийн албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр батлуулж 20,0 сая төгрөгийн 4 ш суурин компьютер, 1 ш нөөтбүүк, 4 ш принтерээр хангасан. Хулд, Баянжаргалан суманд орон нутгийн хөгжлийн сангийн 53,0 сая төгрөгийн ДӨТ машин, бүртгэгчийн тоног төхөөрөмж, Дэрэн, сумын бүртгэгчийн суурин компьютер, Өндөршил, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын бүртгэгч нарт төлбөрийн пос машин, Сайнцагаан сумын улсын бүртгэгчид зөөврийн компьютер зэргийг шийдвэрлэсэн.	100
Говь-Угтаал сумын Морьт багийн төвийн барилгын гүйцэтгэгч "Ривал констракшн" ХХК. Ажил 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад оруулсан.	100

Архивын тасгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг сайжруулах үүднээс 2,5 сая төг үнэ бүхий принтерээр хангасан. Тоног төхөөрөмжийн хангалт 90 хувьтай.	70
Энэ онд 2 ш нягтруулсан шүүгээгээр Төрийн архивыг хангахаар төлөвлөсөн боловч хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалан шийдвэрлэгдээгүй.	
2024 онд Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээг уул уурхай эрхлэгч 20 ААН-тэй байгуулсан. Гэрээний хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн санд 360.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төвлөрүүлэхээр гэрээлсэн байна. Аймгаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд 160,0 сая, холбогдох сумд болон аймгийн өвөлжилт бусад хандивт 468, 0 сая, сумдын 100 жилийн ойн арга хэмжээнд 558 сая нийт 2024 онд 1546,0сая төгрөгийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байна.	100
Аймгийн Засаг даргын 2024.09.30 өдрийн А/668 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 23 талбайд хийсэн. Хяналт шалгалтыг Геологи Уул уурхай, Эрчим хүч, Хөдөлмөр хамгаалал, Байгаль орчин, Нийгмийн хамгааллын хяналтын Улсын байцаагчид холбогдох яамнаас төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжаар давхар хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. 2024 онд 29 уурхай үйл ажиллагаа явуулахаар Уулын ажлын төлөвлөгөө батлуулсан байна. Тайлант онд иргэн, аж ахуйн нэгжид хийсэн 3 удаагийн хяналт шалгалтаар: •Албан шаардлага – 11 ☐ Үйл ажиллагааг зогсоох акт – 0 ☐ Зөвлөмж – 12 ☐ Албан мэдэгдэл - 11 ☐ Торгууль - 117,700,000 төгрөг ☐ Нөхөн төлбөрийн актаар 31,680,000 төгрөгийг хүү торгуулийн дансанд бүрэн төлж барагдуулсан байна. Хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд саад учруулсан хэрэг зөрчил илрээгүй.	100
5 сумын хэмжээнд 10 аж ахуй нэгж өөрийн хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд тухайн жилийн хайгуулын ажлыг гүйцэтгэж байна. Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн ажлын албаныхан, Засаг даргын орлогч, байгаль орчны мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч зэрэг холбогдох албан хаагчдад ашигт малтмал уул уурхайн чиглэлээр нийт 156 албан хаагчдад мэдээлэл өгсөн. Мөн Баянжаргалан сумын Энгэр ус багын 56 иргэнд Үнэн бэх ХХК нэмэлт хайгуулын ажлыг танилцуулсан Луус суманд хайгуулын талбайн талаар 40 иргэнд, Говь-Утгаал суманд Шанжин -Орд ХХК Хонгор багийн 73 иргэн нийт 325 иргэнд ойлголт мэдээлэл өгснөөр уул уурхайн мэдээлэл авсан иргэдийн тоо 855 хүрсэн байна. Ашигт малтмал, газрын тосны газрын говийн бүсийн төлөөллийн газартай хамтран 3 дугаар улиралд уул уурхайн лиценз бүхий сумдын удирдлагууд болон ард иргэдэд уул уурхайн мэдээлэл сургалтыг зохион байгуулсан.	100
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслөөр махны үхрийн хагас эрчимжсэн аж ахуй байгуулах 2 төсөлд 180.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж Адаацаг Хонгор ажнай, Их наран говь 2 ААН дэмжигдэн үйл ажиллагаагаа явуулж байна.	100

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 15 сумын 3815 малчин өрхийн 1666736 толгой хонь, 139800 толгой хурга, 304212 толгой ишиг нийт 2110748 толгой хонь, төл хамруулсан.Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт 4211 өрхийн 1,679,191 толгой хонь, 218728 толгой хурга нийт 1,897,919 толгой мал хамруулсан. Нийт 4.008.667 толгой малыг хамрууллаа.	100
Сайнцагаан, Дэрэн суманд Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч нийт 580 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн.Төл бойжилт 85 хувьтай байна. нийт 2350 хонинд хээлтүүлэг хийсэн байна.	100
Малчны хөгжлийг дэмжих төвийн зураг төсөв ТЭЗҮ боловсруулах ажил 50 хувьтай хийгдсэн.	50
Хулд сумын хонины ноос хяргах байгууламж, тоног төхөөрөмжийн ажлыг "Энх-Өргөө" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад орсон.	100
Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тендер нээж гүйцэтгэчийг шалгаруулсан боловч тус тендерт гомдол гарсан. Сангийн яамнаас шийдвэрийг хүлээж байна.	30
Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хаврын тариалалтад зориулан олгож буй төмс, хүнсний ногооны 14 нэр төрлийн 80 хувийн хөнгөлөлттэй 3,9 тн буюу 56,8 сая. төгрөгийн үрийг татан авч, 15 суманд хуваарилан, 145 тариаланчдад 20 хувийн үнийн хөнгөлөлттэй үрийг олгож дэмжиж, хамтран ажилласан.	100
Аймгийн төвд "Торгоны зам" олон улсын авто ралли уралдааны тамирчид 260 хүн оролцсон. Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын Говь каравансерай баазтай хамтран "Персейдын солирын бороо" эвент арга хэмжээг зохион байгуулж 146 зочид Төлөөлөгчид оролцсон. СайханД воо сумын О нгийн хийд байгалийн дурсгалт "Адуучны өв соёлын баяр" эвент арга хэмжээг зохион байгуулж 450 гадаад, дотоодын жуулчин оролцсон. Улаанбаатар хотод "Тансаг айраг" фестивалийг зохион байгуулж 220 хүн оролцсон. Мөн Мандалговь хотод "Говийн өнгө, Говийн залуус" арга хэмжээг зохион байгуулж, 512 дэмбээчин, 129 айраг уугч оролцож, 10000 хүн уг үйл ажиллагааг үзэж, Нийт 5 эвент үйл ажиллагаанд 11076 100 гадаад, дотоодын жуулчид үзэж	100
"Dundgovi" аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж байна. Цахим платформд 141 аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл оруулж, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, мэдээлэл тогтмол хийж 491 иргэн гар утсандээ татаж суулгасан. Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаад 37549 жуулчин ирсэн байна. Өмнөх оноос гадаадын жуулчдын тоо 17%-аар өссөн үзүүлэлттэй байна.	100
"Дундговьд зочилъё" аялал жуулчлалын төлөвлөгөөг 10 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай хэрэгжсэн.	100
Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газарт Палентелогийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлын зураг төсвийг Ланд өвнөр компани гүйцэтгэсэн.ТЭЗҮ, зураг төсвийг 11 сард хүлээн авсан.	100

Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор жуулчны баазуудад байгаа сул орон тооны "Ажлын байрны өдөрлөг"-ийг Политехникийн коллежийн 93 оюутанд мэдээлэл өгч, "Dundgobi" аппликейшныг сурталчилсан. Аялал жуулчлалын 7 хоног арга хэмжээнд тус аймгийн зочлох үйлчилгээний салбарын 7 үйлчилгээний ажилтан, Хорека зочлох үйлчилгээний байгууллагаас явуулсан "Жуулчдаа дайлах монгол зоог" сургалтад 6 үйлчилгээний ажилтан, нийт 3 сургалтад 170 албан хаагч хамрагдсан.	100
Эдийн засаг хөгжлийн яамнаас боловсруулсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Дундговь аймгийн Говь-Угтаал, Сайнцагаан, Эрдэнэдалай бүсийн тулгуур төвөөр онцолж дээрх сумдад ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих терминал логистикийн төвийн ТЗЗҮ боловсруулахаар ЭЗХЯ-ны бодлогод тусгагдаж төсөв батлагдсан.	0
Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын 2 хос хэлхээ 287 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын "Өвөрхангай", "Мандал" дэд станцуудын өргөтгөл төслийн ажилтай холбоотой байгаль, орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдэж байгаад дамжин өнгөрөх Эрдэнэдалай, Луус, Сайнцагаан сумдын багуудын иргэдийн нийтийн хэлэлцүүлгийг 12 дугаар сард хамтран зохион байгуулан ажилласан. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын эхний үе шат болох 17 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс 2024 оны УТХО 7.8 тэрбум төгрөг батлагдаж гүйцэтгэчийг шалгаруулж ажил хийгдэж байна.	100
Бор овооны энгэрийн замыг АЗДТГ-ын зүүн зогсоолтой холбох ажлын гүйцэтгэгч "Сакод импорт" ХХК. Авто зам, зогсоолын суурийн далангийн ажил хийгдсэн. Ажлын явц 100 хувьтай байна.	100
Сайнцагаан сумын 19км авто замын засварын гүйцэтгэгчээр "Дундговь авто зам" ХХК шалгарч гэрээ байгуулан, ажил дууссан.	100
Иргэд өргөдөл гомдол, санал хүсэлтээ орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр гар утаснаасаа илгээх, шийдвэрлэлтээ харах боломжоор хангах гар утасны аппликейшны нэвтрүүлэх хөрөнгийн асуудлыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 20 сая төгрөг шийдвэрлүүлсэн.Ажил гүйцэтгэл 100 хувьтай байна.	100
Монгол улсын бүсчилсэн хөгжлийн зорилт "Алсын хараа-2050", Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого, "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим хөгжил харилцаа холбооны яамны санаачилгаар орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэх, өндөр бүтээмжтэй, үр ашигтай, эдийн засаг, нийгмийг бий болгоход чиглэсэн дэвшилтэт технологи, программ хангамжийг сурталчлан таниулах зорилготой "ЦАХИМД ХЭВШЬЕ" уриатай "DIGITAL FIRST-D1" арга хэмжээг зохион байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цахим аймаг төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч холбогдох албан байгууллагуудад хуваарилсан.	
Эрдэнэдалай, Өлзийт, Дэлгэрцогт 3 сумд 4G сүлжээтэй болсон .	100

Дундговь аймгийн дулааны станц барих төсөл"-ийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын "Бьюксан инженеринг" компани шалгарч, 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээнд төслийг 26.5 сарын хугацаанд гүйцэтгэхээр тусгасан бөгөөд 2024 оны 12 дугаар сард дулааны станцыг ашиглалтад оруулах байсан боловч төслийн хэрэгжилт удаашралтай байгааг гүйцэтгэгч "Бьюксан инженеринг" компанийн зүгээс санхүүгийн хүндрэлтэй тулгарсан байна. Санхүүжилтийн төсөвт өртөг:10,096,675 ам.доллар /гүйцэтгэгчид олгосон санхүүжилт-5,082,999 ам.доллар (50%)/ Төсөл хэрэгжиж дуусах хугацаа: 2024.12.05 Төслийн хэрэгжилт:Зураг төсөл - 86.56% Худалдан авах ажиллагаа - 47.47хувьтай байна. 2024 онд Дулааны станцын угсралтын ажил зуух угсралт усан шахалт хийхэд бэлэн болсон, үндсэн барилгын краказ ¼ хэсэг, цахилгааны дэд станц барилга, нүүрс хүлээн авах барилгуудын цутгалтын ажил, конвейр 1, нүүрс бутлуур, утаа сорогчын суурийн цутгалтын хийж дуусан. Ажлын гүйцэтгэл 45% байна.	28.5
ЭХЯаманд тендер зарлагдаж гүйцэтгэгч байгууллагаар нь Инфраструктур ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.	100
Сайнцагаан сумын 30-р байрны дээвэр, фасадны ажлыг "Роуд дэвэлопмэнт" ХХК 147.0 сая төгрөгөөр, 6-р байрны дээврийн засварын ажлыг "Акшус" ХХК 71.0 сая ,12-р байрны дээврийн засварын ажлыг Лорд хаус ХХК гүйцэтгэж 100 хувийн гүйцэтгэлтэй бүрэн дууссан.	100
	85.2

